



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ
ТӨВ” ТӨҮГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын код: САГ-2018/41/СТА-ТӨҮГ

АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

**САГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх
аудитор** Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахимхаяг: naranchimegts@audit.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 261885

Цахимхаяг: sambuunyamya@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ЗГ-ын IV байр

Бага тойруу 6, Улаанбаатар 46

Цахим хуудас: www.audit.mn

“Цэгцтөв богд Аудит” ХХК-ийн

Аудитын багийн ахлагч Н.Цэрэнханд

Утас:99901517

Улаанбаатар хот



Агуулга

1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	1
2. АУДИТЫН ТАЙЛАН	1
2.1 ОРШИЛ	1
2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	1
2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	2
2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ҮР ДҮН	3
2.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН	3
2.6 ДОТООД ХЯНАЛТ	3
2.7 ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР	4
2.8 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	4
2.9 ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР	4
2.10 ГОЛ, ОНЦЛОГ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР	4
2.11 АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР	5
2.11.1 Мөнгөн хөрөнгийн талаар	5
2.11.2 Авлагын талаар	5
2.11.3 Бараа материалын талаар	6
2.11.4 Үндсэн хөрөнгийн талаар	6
2.11.5 Татварын тооцооллын талаар	7
2.12 МАТЕРИАЛЛАГ БУС ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР	7
2.13 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	7
2.14 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД	7
2.15 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	7
2.16 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ	8
3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	10
3.1 Санхүүгийн тайлагналын талаар	11
3.2 Мөнгөн хөрөнгийн талаар	11
3.3 Авлагын талаар	12
3.4 Бараа материалын талаар	12
3.5 Үндсэн хөрөнгийн талаар	13
3.6 Татварын тооцооллын талаар	13
3.7 Өглөгийн талаар	14
4. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	17
4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	

1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/693
танай _____ -ны № _____ -т

“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ
ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.ЦЭРЭН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэргээгдэх эрчим хүчний төв” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Сэргээгдэх эрчим хүчний төв” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Сэргээгдэх эрчим хүчний төв” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус компанид мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Сэргээгдэх эрчим хүчний төв” ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус газрын захирал Ц.Цэрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, орлого, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн авлага, өглөгийг үнэн зөв тайлагнах, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах ажил зохион байгуулах, үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу олж бэлтгэх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно


2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд гэрээгээр “Цэгцтөв Богд аудит” ХХК /САГ-2018/41/СТА-ТӨҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.



Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-наас 2018 оны 03 дугаар сарын 12-ныг хүртэл хийхээр төлөвлөн “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн 2 дугаар багийн аудитор Д.Үүрийнтуяа, аудиторын туслах ажилтан Г.Дашбалжир, Х.Уранчимэг нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ нь 2017 оны санхүүгийн тайланг “Цэгцтөв богд аудит” ХХК-д 2018 оны 02 дугаар 21-ний өдөр 30 дугаар албан бичгээр ирүүлсэн.

“Цэгцтөв богд аудит” ХХК нь аудитыг 2018 оны 02 дугаар сарын 25-наас 2018 оны 03 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын удирдлагад гардуулна.


2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ нь Монгол Улсын Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, ХХОАТ-ын тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Зөрчлийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын үйл ажиллагааны зорилт нь төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой сэргээгдэх эрчим хүчний нөөцийн нарийвчилсан хэмжилт судалгаа хийх, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар төсөвт судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хэрэгжүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төсөл боловсруулах, сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламжид техникийн хяналт тавих, гадаад, дотоодод үйлдвэрлэсэн сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжид туршилт хийх, магадлал гаргах, шинээр баригдах эрчим хүчний эх үүсгүүрийн хүлэмжийн хийн ялгарлын бууралтад магадлагаа нотолгоо хийх, сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсгүүр барих, тоног төхөөрөмж угсрах, сургалт зохион байгуулж сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн ажиллахад оршиж байна.

Анх 1989 онд Сэргээгдэх эрчим хүчний Шинжлэх Ухаан Үйлдвэрлэлийн Нэгдэл байгуулагдсан ба Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 80 дугаар тэмдэглэлийг үндэслэн Төрийн өмчийн хорооны 2009 оны 13



дугаар сарын 12-ны өдрийн 58, 146 дугаар тогтоолоор Нарны зайн үйлдвэрийг түшиглэн “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ҮР ДҮН

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 46-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 46 дугаар тушаалаар “Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх” Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Бид “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн “Венеца” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

2.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны орлого, үр дүнгийн тайлангийн цэвэр орлого 868.8 сая төгрөгийн 2 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр тооцов.

2.6 ДОТООД ХЯНАЛТ



Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна. Аудитын баг байгууллагын удирдлагад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа, тайлагнал, дотоод хяналтанд илэрсэн сул талуудыг тухай бүр мэдэгдэж зөвлөмж өгч ажилласан.

2.7 ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ 2017 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 310 дугаар тушаалаар батлуулж ажилласан байна. Тус төлөвлөгөөгөөр нийт 665.8 сая төгрөгийн орлого олж 665.8 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ. Тайлант оны орлого үр дүнгийн тайлангаас харахад гүйцэтгэлээр 868.8 сая төгрөгийн цэвэр орлого, 25.6 сая төгрөгийн бусад орлого нийт 885.2 сая төгрөгийн орлого олж батлагдсан төлөвлөгөөг 219.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Зардлын хувьд гүйцэтгэлээр нийт 470.8 сая төгрөгийг зарцуулж 414.3 сая төгрөгийн татварын өмнөх, 371.7 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан байна.

2.8 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас <http://nrec.mn/> сайтад шилэн дансны цэсийг холбосон. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ нь www.shilendans.gov.mn цахим сайтад I) төсөв/гүйцэтгэл; II) хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт; III) бусад; цэсэнд хуульд заасан хугацааны дагуу мэдээлэх үүрэгтэй. Тус хүрээлэн 2017 онд шилэн дансны тухай хууль, журмын дагуу холбогдох мэдээллийг цахим хуудсанд мэдээлсэн байна.


2.9 ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу 10 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 46 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдлүүдээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, цалин хөлс, зардлын дансны гүйлгээтэй холбоотой зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.10 ГОЛ, ОНЦЛОГ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явдал санхүүгийн зөрчилгүй САНАЛ ДҮГНЭЛТ



тайланд нөлөөлөхүйц хэмжээний авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг зардлын дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, зардал, хөрөнгийн 80 хувийг эзэлж байна.

2.11 АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР

Аудитын явцад аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансдын нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.11.1 Мөнгөн хөрөнгийн талаар

- 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх кассан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх журманд заасан хязгаараас их байна. Энэ нь "Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв" ТӨҮГ-ын захирлын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр тушаалаар батлагдсан "СЭХҮТ" ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх журмын 1. "Кассанд 1.0 саяас дээш дүнтэй бэлэн мөнгө байршуулахгүй байх.", 2. "1.0 саяас дээшхи дүнтэй бэлэн мөнгийг банкинд заавал тушааж байх" заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Санхүүгийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.


- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар буюу гэрээгүйгээр нийт 4.4 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; 13 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2.11.2 Авлагын талаар

- Тайлант хугацааны эхэнд үлдэгдэлтэй байсан авлага, өглөгийг барагдуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого худалдан авагчтай тооцоо



хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Он дамжсан насжилт авлагыг барагдуулах ажил зохион байгуулж, барагдуулалтанд хяналт тавьж ажиллахыг зөвлөн албан шаардлага хүргүүлэв.

- Найдваргүй авлагын нөөц байгуулаагүй. Энэ нь Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 46 дугаар тушаалаар батлагдсан Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн 6.6-д "...Найдваргүй авлагын нөөцийг жил тутам авлагын дундаж үлдэгдлээс 3 хүртэлх хувиар байгуулна." заалтыг мөрдөөгүй.

Шийдвэрлэсэн нь:

Найдваргүй авлагын нөөцийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу байгуулж бүртгэх зөвлөмж өгөв.

2.11.3 Бараа материалын талаар

- Нийт 2.6 сая төгрөгийн шатахууныг шууд зардлаар бүртгэсэн. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврын 2.1.4-д "...Бараа материалд ... үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гэж байгаа материал буюу хангамжийн зүйлс хамрагдана." заалтыг мөрдөөгүй.

Шийдвэрлэсэн нь:

Бараа материалыг орлогод аван зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөв.

2.11.4 Үндсэн хөрөнгийн талаар

- Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан жишиг хугацааг мөрдөөгүй. Энэ нь Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 46 дугаар тушаалаар батлагдсан Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн 9.9 "Үндсэн хөрөнгийн ашиглалтын жишиг хугацаа"-г мөрдөөгүй.

Шийдвэрлэсэн нь:

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо ашиглалтын жишиг хугацааг баримталж ажиллах зөвлөмж өгөв.

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр батлагдаагүй 7.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэсэн. Энэ нь Захиралтай байгуулсан Контракт (Гэрээ)-ний 3.7 Захирал дараах асуудлыг зөвхөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр шийдвэрлэх үүрэгтэй: 3.7.2-т үйлдвэрийн газрын үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгө олж авах, данснаас хасах, захиалах, шинээр авах;" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Үндсэн хөрөнгийг олж бэлтгэхдээ холбогдох шийдвэрийг авч ажиллаж байх зөвлөмжийг өгөв.

- Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн тэг үлдэгдэлтэй хөрөнгүүд байна. Энэ нь УСНББОУС 17-49-д "Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Үндсэн хөрөнгийг цаашид ашиглах эсэх талаар шийдвэр гарган ашиглахаар бол дахин үнэлгээ хийх зөвлөмж өгөв.

2.11.5 Татварын тооцооллын талаар

Татварын тооцооны үлдэгдлийн баталгаажуулалтын акт болон тус байгууллагын санхүүгийн тайлангаарх Хувь хүний орлогын албан татвар, Автотээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын өглөг, Нэмэгдсэн өртгийн албан татварын авлагыг нийт 2.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2.7-т "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих,..." заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Аж ахуйн нэгж байгууллагын татвар, төлбөр, хураамж шимтгэлийн тооцооллыг шалган хяналт тавьж, нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тайлагнаж ажиллах зөвлөмж өгөв.

2.12 МАТЕРИАЛЛАГ БУС ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР

Материаллаг бус 16.9 сая төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

2.13 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад анхаарал татахуйц чухал асуудал гараагүй болно.

2.14 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.15 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитаар нийт 16.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй 7 бүлэг зөвлөмжийг Менежментийн захидлаар байгууллагын удирдлагад хүргүүлэв.

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ



“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй ба менежментийн захидлаар 6 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 3 зөвлөмжийг биелүүлж, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

“БНХАУ-аас худалдан авсан хөрөнгөнд гаалийн бүрдүүлэлтийг нөхөн хийж, холбогдох татварыг төлөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Гаалийн ерөнхий газрын мэргэжилтнээс хэрхэн нөхөн бүрдүүлэлт хийх талаар тодруулхад нөхөн бүрдүүлэлт хийх боломжгүй байдаг талаар болон харьяа татварын хэлтэст мэдэгдэж зөрчлийг арилгахаар холбогдох албан тушаалтнуудтай уулзан ажиллаж байна. Мөн ашиглалтгүй байгаа бараа, бүтээгдэхүүнийг худалдан борлуулж, эргэлтийн хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлэхээр агуулах чөлөөлөх худалдаа болон нээлттэй хаалганы өдөрлөгөөр уг бараа материалыг худалдан борлуулах санал оруулсан боловч дангаараа үнэ хүрэхгүй, хэрэглэгчид ашиглах боломжгүйгээс зарагдаагүй. Иймд 2018 онд нарны цахилгаан үүсгүүр үйлдвэрлэхэд түүхий эд болгон ашиглахаар зорилтот түвшиндээ тусгасан” гэж хариу ирүүлсэн болно.

Зөрчлийг арилгуулах 2 албан шаардлагын биелэлт 75 хувьтай байна.

2.16 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.


Аудитлагдсан санхүүгийн тайлан 14 хуудас, хавсралтууд 6 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН
АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ..... Н.ЦЭРЭНХАНД Огноо:

БЭЛТГЭСЭН:

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР..... Д.ҮҮРИЙНТУЯА Огноо:





YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

**САГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх
аудитор** Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахимхаяг: naranchimegts@audit.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
Цахимхаяг: sambuunyamy@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: ЗГ-ын IV байр
Бага тойруу 6, Улаанбаатар 46

**“Цэгцтөв богд Аудит” ХХК-ийн
Аудитын багийн ахлагч Н.Цэрэнханд**
Утас:99901517

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Санхүүгийн тайлагналын талаар.....1

Асуудал 2
Мөнгөн хөрөнгийн талаар2

Асуудал 3
Авлагын талаар.....3

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 4
Бараа материалын талаар.....4

Асуудал 5
Үндсэн хөрөнгийн талаар.....5

Асуудал 6
Татварын тооцооллын талаар.....6

Асуудал 7
Өглөгийн талаар.....7

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Улаанбаатар хот

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгдсэн ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Энэ нь “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.1 Санхүүгийн тайлагналын талаар

- Аудитын ажиглалт**
- ✓ Дансны төлөвлөгөөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу шинэчилж мөрдөөгүй.

- ✓ Найдваргүй авлагын нөөц байгуулаагүй.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

Тэргүүлэх ач холбогдол №1

- Аудитын зөвлөмж**
- ✓ Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт” ба Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 46 дугаар тушаалаар батлагдсан Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 4. “Нягтлан бодох бүртгэлийн дансны төлөвлөгөө”-г мөрдөх

- ✓ Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 46 дугаар тушаалаар батлагдсан Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 6.6-д “...Найдваргүй авлагын нөөцийг жил тутам авлагын дундаж үлдэгдлээс 3 хүртэлх хувиар байгуулна.” заалтыг хэрэгжүүлэх

Төсвийн захирагчийн харуу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр болов.

3.2 Мөнгөн хөрөнгийн талаар

- ✓ 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх кассан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх журманд заасан хязгаараас их байна.

- ✓ Анхан шатны бүрдэл дутуу баримтаар буюу гэрээгүйгээр нийт 4.4 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэн.

Тэргүүлэх ач холбогдол №1

- ✓ “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр тушаалаар батлагдсан “СЭХҮТ” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх журмын 1. “Кассанд 1.0 саяаас дээш дүнтэй бэлэн мөнгө байршуулахгүй байх.”, 2. “1.0 саяас дээшхи дүнтэй бэлэн мөнгийг банкинд заавал тушааж байх” заалтыг мөрдөх.

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; 13 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.7-д “Анхан шатны баримтын бүрдөлгүй ажил, гүйлгээг бүртгэх, төрийн аудитын байгууллага тусгахыг хориглоно.” заалтыг хэрэгжүүлэх

01

ЗӨРШЛӨГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр болов.

3.3 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Аудитын ажиглалт

- ✓ Тайлант хугацааны эхэнд үлдэгдэлтэй байсан авлага, өглөгийг барагдуулаагүй.
- ✓ Бусад авлага дансыг 0.1 сая төгрөгөөр сөрөг утгаар тайлагнасан.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

Аудитын зөвлөмж

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг тус тус мөрдөх
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2. Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" гэж заасныг хэрэгжүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр болов.

3.4 Бараа материалын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

- ✓ Нийт 2.6 сая төгрөгийн шатахууныг шууд зардлаар бүртгэсэн.

Эрсдэлүүд


Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

Аудитын зөвлөмж

- ✓ Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 249 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврын 2.1.4-д "...Бараа материалд ... үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гэж байгаа материал буюу хангамжийн зүйлс хамрагдана." заалтыг мөрдөх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор



ирүүлэхээр болов.

3.5 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

- ✓ Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан жишиг хугацааг мөрдөөгүй.
- ✓ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр батлагдаагүй 7.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэсэн.
- ✓ Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн тэг үлдэгдэлтэй хөрөнгүүд байна.
- ✓ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 131 дүгээр тушаалаар акталж данснаас хассан хөрөнгө 48.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

Аудитын зөвлөмж

- ✓ Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 46 дугаар тушаалаар батлагдсан Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн 9.9 "Үндсэн хөрөнгийн ашиглалтын жишиг хугацаа"-г мөрдөх
- ✓ Захиралтай байгуулсан Контракт (Гэрээ)-ний 3.7 Захирал дараах асуудлыг зөвхөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр шийдвэрлэх үүрэгтэй: 3.7.2-т үйлдвэрийн газрын үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгө олж авах, данснаас хасах, захиалах, шинээр авах," гэж заасныг хэрэгжүүлэх.
- ✓ УСНББОУС 17-49-д "Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" заалтыг мөрдөх
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл.Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т “үнэн зөв байх,” заалтыг мөрдөх

Төсвийн захирагчийн харуу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр болов.

3.6 Татварын тооцооллын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

- ✓ Татварын тооцооны үлдэгдлийн баталгаажуулалтын акт болон тус байгууллагын санхүүгийн тайлангаарх Хувь хүний орлогын албан татвар, Автотээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Суутгагчийн хувь хүнд

Аудитын зөвлөмж

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2.7-т "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих,..." заалтыг хэрэгжүүлэх

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

олгосон орлогоос суутгасан албан татварын өглөг, Нэмэгдсэн өртгийн албан татварын авлагыг нийт 2.1 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр болов.

3.7 Өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

- ✓ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ,ҮЗ,/

Аудитын зөвлөмж

- ✓ Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний 2.8-д "Түрээслүүлэгч нь түрээслэгчээс авсан түрээсийн төлбөрийн нийт үнийн дүнгийн ... хувийг Төрийн өмчийн хорооны төрийн сан дахь дансанд сар бүр төвлөрүүлнэ." заалтыг хэрэгжүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулан зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхээр болов.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ Н.ЦЭРЭНХАНД

Огноо:

БЭЛТГЭСЭН:

“ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР Д.ҮҮРИЙНТУЯА

Огноо:




4. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	2016.12.31	2017.12.31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,417,852.45	91,713,645.21
1.1.02	Дансны авлага	55,389,544.61	51,131,308.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	-	22,387,052.07
1.1.04	Бусад авлага	33,812,559.38	24,714,440.38
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.06	Бараа материал	138,856,530.32	179,717,127.09
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	25,298,128.48
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	229,476,486.76	394,961,701.23
1.20	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	368,382,454.28	358,323,125.42
1.2.02	Биет бус хөрөнгө	300,278.41	-
1.2.03	Биологийн хөрөнгө	-	-
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.07	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	368,682,732.69	358,323,125.42
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	598,159,219.45	753,284,826.65
2.00	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.10	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	128,659,522.94	41,058,000.64
2.1.1.02	Цалингийн өглөг	31,293,783.08	1,877,723.33
2.1.1.03	Татварын өр	66,159,807.20	26,087,148.20
2.1.1.04	НДШ-ийн өглөг	27,666,804.03	-
2.1.1.05	Богино хугацаат зээл	108,508,345.74	58,508,345.74
2.1.1.06	Хүүний өглөг	-	-
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12		-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	362,288,262.99	127,531,217.91
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.01	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.05		-	-



2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.20	Өр төлбөрийн нийт дүн	362,288,262.99	127,531,217.91
2.30	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	663,670,844.58	663,670,844.58
2.3.02	- хувийн	-	-
2.3.03	- хувьцаат	-	-
2.3.04	Халаасны хувьцаа	-	-
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	178,847,922.38	178,847,922.38
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	43,794,301.00	53,340,848.30
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(650,442,111.50)	(270,106,006.52)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	371,728,433.07
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(650,442,111.50)	(641,834,439.59)
2.3.10		-	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	235,870,956.46	625,753,608.74
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	598,159,219.45	753,284,826.65

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	2016.12.31	2017.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	306,696,941.44	868,811,244.90
2	Борлуулалтын өртөг	156,026,374.20	13,382,351.13
3	Нийт ашиг(алдагдал)	150,670,567.24	855,428,893.77
4	Түрээсийн орлого	7,527,272.72	7,227,272.72
5	Хүүний орлого	16,738.21	1,892,840.68
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	145,298.00
8	Орлогын дүн	7,544,010.93	9,265,411.40
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	322,627,455.62	438,683,449.13
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
12	Зардлын дүн	322,627,455.62	438,683,449.13
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(5,012,198.47)	(13,189.36)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	7,090,909.09
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	(19,489,069.29)	(18,773,586.90)
17	Олз, гарзын дүн	(24,501,267.76)	(11,695,867.17)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(188,914,145.21)	414,314,988.87
19	Орлогын татварын зардал	1,673.82	42,586,555.80
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(188,915,819.03)	371,728,433.07
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(188,915,819.03)	371,728,433.07
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан


Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	НТК	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадвад валютын нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан Ашиг	Нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	663,670,844.58	-	-	178,847,922.38	-	43,794,301.00	(415,462,969.18)	470,850,098.78
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	(46,063,323.29)	(46,063,323.29)
3	Залруулсан үлдэгдэл	663,670,844.58	-	-	178,847,922.38	-	43,794,301.00	(461,526,292.47)	424,786,775.49
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	(188,915,819.03)	(188,915,819.03)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
9	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	663,670,844.58	-	-	178,847,922.38	-	43,794,301.00	(650,442,111.50)	235,870,956.46
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	8,607,671.91	8,607,671.91
11	Залруулсан үлдэгдэл	663,670,844.58	-	-	178,847,922.38	-	43,794,301.00	(641,834,439.59)	244,478,628.37
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	371,728,433.07	371,728,433.07
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	9,546,547.30	-	9,546,547.30
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
17	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	663,670,844.58	-	-	178,847,922.38	-	53,340,848.30	(270,106,006.52)	625,753,608.74

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	2016.12.31	2017.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	344,946,521.96	971,285,889.56
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	35,208,088.72	913,550,000.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	342,836.00	4,169,742.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	309,395,597.24	53,566,147.56
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	345,969,142.76	890,682,937.48
1.2.1	Ажиллагчдад төлсөн	120,689,965.57	238,534,348.94
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	21,235,536.36	80,604,896.74
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	113,667,052.40	42,690,571.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	11,049,278.00	26,941,525.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,273,032.00	14,019,130.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	1,412,500.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,108,425.36	194,120,790.59
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	70,945,853.07	292,359,175.21
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,022,620.80	80,602,952.08
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	9,692,840.68
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	7,800,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	1,892,840.68
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	9,692,840.68
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-



“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,022,620.80	90,295,792.76
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,440,473.25	1,417,852.45
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,417,852.45	91,713,645.21